



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/94

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэсант сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэсант сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийн хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоосонтой холбоотой мөнгөн хөрөнгийн данс 280,546.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Эрдэнэсант сумын эрүүл мэндийн төв нь тусгай зөвшөөрлөөр эргэлтийн эмийн сангаар дамжуулан эм худалдан борлуулах эмийн сангийн үйлчилгээг эрхлэн явуулдаг, эм борлуулсны орлого 61,275.0 мянган төгрөг цахим баримтад илүү шивэгдсэн байна.

Эргэлтийн эмийн сан нь байрны түрээсийн төлбөр, түрээсийн орлого төсөвт төвлөрүүлээгүй, төсвөөс байр ашиглалтын төлбөр, эм зүйчийн цалин хөлс, шимтгэл, гэрэл цахилгаан, дулаан, ус, хог, тээвэр, шатахууныг зарцуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг хэргэжүүлэхээр төлөвлөснөөс 93,5 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээлэлийг хамруулаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>325,122,520.83</u>	<u>410,318,345.47</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	245,492,122.68	280,546,313.55
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	245,492,122.68	280,546,313.55
3121	Төгрөг	245,492,122.68	280,546,313.55
31211	Төрийн сангийн харилцах	245,492,122.68	280,546,313.55
33	АВЛАГА	00.00	17,885,396.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	17,885,396.00
35	БАРАА МАТЕРИАЛ	79,630,398.15	111,886,635.92
351	Түүхий эд материал	79,630,398.15	111,886,635.92
35110	Тусгай зориулалттай материал	53,508,670.62	97,102,222.47
35130	Эм боох материал	26,121,727.53	14,784,413.45
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>333,663,507.93</u>	<u>327,893,956.56</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	333,663,507.93	327,893,956.56
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	317,521,507.93	311,751,956.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	243,514,269.00	272,314,269.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-48,482,421.62	-59,407,514.42
39203	Авто-тээврийн хэрэгсэл	118,400,000.00	88,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-85,422,222.24	-64,738,888.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	196,882,505.60	136,687,805.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-130,081,226.25	-79,692,850.62
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,089,177.95	29,889,177.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,288,230.51	-12,609,698.03
39214	Бусад үндсэн хөрөнгө	64,900.00	64,900.00
39217	Ном	844,756.00	844,756.00
393	Биет бус хөрөнгө	16,142,000.00	16,142,000.00
39301	Программ хангамж	634,000.00	634,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-634,000.00	-634,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	16,142,000.00	16,142,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>658,786,028.76</u>	<u>738,212,302.03</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>658,786,028.76</u>	<u>738,212,302.03</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	658,786,028.76	738,212,302.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	311,267,812.78	311,267,812.78
51101	Өмч: - төрийн	295,125,812.78	295,125,812.78
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	16,142,000.00	16,142,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	215,907,927.35	295,334,200.62
51210	Өмнөх үеийн үр дүн	215,907,927.35	215,907,927.35
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	79,426,273.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	131,610,288.63	131,610,288.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>658,786,028.76</u>	<u>738,212,302.03</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,091,827,661.46	1,085,398,430.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	81,408,501.46	51,301,554.72
120	Нийтлэг татварын бус орлого	81,408,501.46	51,301,554.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	81,408,501.46	51,301,554.72
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	81,408,501.46	50,301,554.72
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,010,419,160.00	1,034,096,875.71
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	250,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,903,300.00	45,961,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,903,300.00	45,961,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	964,265,860.00	988,135,775.71
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	964,265,860.00	988,135,775.71
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	752,587,939.69	974,087,254.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	752,587,939.69	974,087,254.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	738,594,470.69	964,729,911.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	414,449,756.62	609,064,403.91
210101	Үндсэн цалин	260,398,410.40	305,303,061.21
210102	Нэмэгдэл	109,501,288.62	225,440,006.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,062,000.00	8,776,000.00
210104	Урамшуулал	38,488,057.60	69,545,335.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,460,577.27	75,010,344.58
210201	Тэтгэврийн даатгал	42,045,385.14	52,322,732.58
210202	Тэтгэмжийн даатгал	3,932,792.58	6,147,613.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,075,674.05	4,847,431.08
210204	Ажилгүйдлийн даатгал	669,529.97	1,058,210.62
210205	Эрүүл мэндийн даатгал	6,737,195.53	10,634,356.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,729,831.00	35,081,756.84
210301	Гэрэл, цахилгаан	4,222,680.00	4,701,881.44
210302	Түлш, халаалт	26,177,151.00	30,049,875.40
210303	Цэвэр, бохир ус	330,000.00	330,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	55,621,825.00	46,039,765.00
210401	Бичиг хэрэг	3,688,860.00	4,193,050.00
210402	Тээвэр, шатахуун	44,249,955.00	36,527,615.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,300,000.00	2,230,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,768,000.00	2,624,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,615,010.00	464,300.00
2105	Нормативт зардал	78,755,611.00	82,405,589.43

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	67,760,011.00	65,189,989.43
210502	Хоол, хүнс	10,995,600.00	13,102,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,758,267.10	12,814,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,396,100.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,131,967.10	00.00
210604	Урсгал засвар	11,230,200.00	12,814,600.00
2107	Томилолт, зочны зардал	2,926,000.00	1,636,000.00
210702	Дотоод албан томилолт	2,926,000.00	1,636,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	1,028,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	649,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	324,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	55,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,892,602.70	101,648,951.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,097,520.00	55,799,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	65,795,082.70	45,849,851.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,993,469.00	9,357,343.16
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	9,357,343.16
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,993,469.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,993,469.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	339,239,721.77	111,311,176.14
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	41,430,930.50	31,884,902.87
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	41,430,930.50	31,884,902.87
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-41,430,930.50	-31,884,902.87
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	297,808,791.27	79,426,273.27

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,010,419,160.00	1,017,211,479.71
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	1,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	1,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,010,419,160.00	1,016,211,479.71
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	250,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,903,300.00	45,961,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,903,300.00	45,961,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	964,265,860.00	970,250,379.71
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	964,265,860.00	970,250,379.71
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	769,649,747.99	982,157,288.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	769,649,747.99	982,157,288.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	755,656,278.99	972,799,945.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	414,449,756.62	609,064,403.91
210101	Үндсэн цалин	260,398,410.40	305,303,061.21
210102	Нэмэгдэл	109,501,288.62	225,440,006.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,062,000.00	8,776,000.00
210104	Урамшуулал	38,488,057.60	69,545,335.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,460,577.27	75,010,344.58
210201	Тэтгэврийн даатгал	42,087,281.12	52,322,732.58
210202	Тэтгэмжийн даатгал	3,932,792.58	6,147,613.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,075,674.05	4,847,431.08
210204	Ажилгүйдлийн даатгал	669,529.97	1,058,210.62
210205	Эрүүл мэндийн даатгал	6,695,299.55	10,634,356.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,729,831.00	35,431,756.84
210301	Гэрэл, цахилгаан	4,222,680.00	5,051,881.44
210302	Түлш, халаалт	26,177,151.00	30,049,875.40
210303	Цэвэр, бохир ус	330,000.00	330,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	62,710,825.00	55,244,965.00
210401	Бичиг хэрэг	3,688,860.00	4,193,050.00
210402	Тээвэр, шатахуун	44,249,955.00	36,527,615.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,300,000.00	2,230,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,988,000.00	2,624,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,484,010.00	9,669,500.00
2105	Нормативт зардал	88,101,322.00	70,223,075.35

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	77,105,722.00	53,371,475.35
210502	Хоол, хүнс	10,995,600.00	13,102,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	80,632,947.10	68,100,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	41,445,780.00	6,700,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	29,401,967.10	364,000.00
210604	Урсгал засвар	9,785,200.00	61,036,600.00
2107	Томилолт, зочны зардал	2,926,000.00	1,636,000.00
210702	Дотоод албан томилолт	2,926,000.00	1,636,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	1,028,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	649,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	324,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	55,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,645,020.00	57,060,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,645,020.00	57,060,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,993,469.00	9,357,343.16
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,993,469.00	9,357,343.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	240,769,412.01	35,054,190.87
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	240,769,412.01	35,054,190.87
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,722,710.67	245,492,122.68
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	245,492,122.68	280,546,313.55

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	311,267,812.78	131,610,288.63	215,907,927.35	658,786,028.76
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	311,267,812.78	131,610,288.63	215,907,927.35	658,786,028.76
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	311,267,812.78	131,610,288.63	215,907,927.35	658,786,028.76
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	311,267,812.78	131,610,288.63	215,907,927.35	658,786,028.76
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	79,426,273.27	79,426,273.27
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	311,267,812.78	131,610,288.63	295,334,200.62	738,212,302.03

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,127,713,000.00	936,196,188.84	191,516,811.16	83.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,127,713,000.00	936,196,188.84	191,516,811.16	83.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,127,713,000.00	936,196,188.84	191,516,811.16	83.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	664,945,800.00	609,064,403.91	55,881,396.09	91.60
210101	Үндсэн цалин	342,046,100.00	305,303,061.21	36,743,038.79	89.26
210102	Нэмэгдэл	229,447,900.00	225,440,006.75	4,007,893.25	98.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,468,400.00	8,776,000.00	-3,307,600.00	160.49
210104	Урамшуулал	87,983,400.00	69,545,335.95	18,438,064.05	79.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,630,200.00	75,010,344.58	9,619,855.42	88.63
210201	Тэтгэврийн даатгал	57,547,800.00	52,322,732.58	5,225,067.42	90.92
210202	Тэтгэмжийн даатгал	6,771,100.00	6,147,613.45	623,486.55	90.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,415,800.00	4,847,431.08	568,368.92	89.51
210204	Ажилгүйдлийн даатгал	1,354,800.00	1,058,210.62	296,589.38	78.11
210205	Эрүүл мэндийн даатгал	13,540,700.00	10,634,356.85	2,906,343.15	78.54
2104	Хангамж, бараа материалын зардал	102,624,200.00	55,244,965.00	47,379,235.00	53.83
210401	Бичиг хэрэг	5,443,500.00	4,193,050.00	1,250,450.00	77.03
210402	Тээвэр, шатахуун	70,555,100.00	36,527,615.00	34,027,485.00	51.77
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,250,000.00	2,230,000.00	20,000.00	99.11
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,625,300.00	2,624,800.00	500.00	99.98
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,750,300.00	9,669,500.00	12,080,800.00	44.46
2105	Нормативд зардал	79,496,100.00	70,223,075.35	9,273,024.65	88.34
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	56,436,400.00	53,371,475.35	3,064,924.65	94.57
210502	Хоол, хүнс	19,309,400.00	13,102,200.00	6,207,200.00	67.85
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,750,300.00	3,749,400.00	900.00	99.98
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	135,875,300.00	66,928,600.00	68,946,700.00	49.26
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,000,000.00	6,700,000.00	43,300,000.00	13.40
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,125,300.00	364,000.00	5,761,300.00	05.94
210604	Урсгал засвар	79,750,000.00	59,864,600.00	19,885,400.00	75.07
2107	Томилолт, зочны зардал	6,000,300.00	1,636,000.00	4,364,300.00	27.27
210702	Дотоод албан томилолт	6,000,300.00	1,636,000.00	4,364,300.00	27.27
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,833,200.00	1,028,500.00	1,804,700.00	36.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	649,500.00	1,350,500.00	32.48

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00	00.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	00.00	100,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	359,200.00	55,000.00	304,200.00	15.31
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	50,000.00	00.00	50,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,307,900.00	57,060,300.00	(5,752,400.00)	111.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,307,900.00	57,060,300.00	-5,752,400.00	111.21
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,127,623,022.68	971,250,379.71	156,372,642.97	86.13
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	881,220,900.00	970,250,379.71	-89,029,479.71	110.10
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	881,220,900.00	970,250,379.71	-89,029,479.71	110.10
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	246,402,122.68	1,000,000.00	245,402,122.68	00.41
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,000,000.00	00.00	100.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	245,402,122.68	00.00	245,402,122.68	00.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	245,492,122.68	-245,492,122.68	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	280,546,313.55	-280,546,313.55	00.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	31	31	00.00	100.00
620001	Удирдах ажилтан	01	01	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	20	20	00.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	10	10	00.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,961,000.00	45,961,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	45,961,000.00	45,961,100.00
210301	Гэрэл, цахилгаан	6,068,200.00	5,051,881.44
210302	Түлш, халаалт	38,232,900.00	30,049,875.40
210303	Цэвэр, бохир ус	360,000.00	330,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,300,000.00	1,172,000.00
210604	Урсгал засвар	1,300,000.00	1,172,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		9,357,343.16
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	45,961,100.00	45,961,100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрдэнэсант сумын эрүүл мэндийн төв нь анх Хүнцэл Цавжид уулын хошууны Угалзат хэмээх газар Навааны Жамбалдорж, Шаравын Тэрбиш нар улаан тарианы сувилагчаар 1934 оноос Нямбуу, Дамбын Хорол нар бага эмчээр ажиллаж, 1944 онд Угалзат багийн төвд 2 ортой бага эмчийн салбар ажиллаж байгаад БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1956 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн зарлигаар Эрдэнэсант сумын хүн эмнэлэг болж их эмчээр Уламбаяр ажиллаж байжээ. 1986 онд 15 ортой эмнэлгийн барилга баригдан ашиглалтад орсноор одоог хүртэл үйл ажиллагаа явуулж байна.

Эрдэнэсант сумын эрүүл мэндийн төв нь зорилгоо "Хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанар аюулгүй байдлыг хангасан ил тод, хариуцлагатай, үр дүнтэй үйлчлүүлэгч төвтэй эмнэлгийн тусламж үйлчилгээний тогтолцоо болгон хөгжүүлнэ гэжээ. Зорилт нь эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээг чанартай хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх, хүн амыг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулж хяналтад авах, үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх гэж зорилт тавин ажиллаж байна.

Тус байгууллага нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сумын хүн амд чанартай, хүртээмжтэй хүргэх, эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйлчилгээ явуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн эмнэлгийн бусад үйл ажиллагаа
- Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Эрдэнэсант сумын эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д "Хот суурийн газрын хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ" үзүүлдэг Эрүүл мэндийн сайдын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Эрдэнэсант сумын эрүүл мэндийн төвийн чиг үүргийг эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх, сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх, сум, тосгоны эрүүл мэндийн төв түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх гэж тодорхойлсон.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд доорх өөрчлөлт орсон байна.

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Эрүүл мэндийн тухай хууль
- ✓ Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль
- ✓ Зөвшөөрлийн тухай хууль
- ✓ Эм, эмнэлгийн хэрэглэлийн тухай хууль
- ✓ Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ

- ✓ Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтад өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэсант сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрдэнэсант сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 79,436.9 мянган төгрөгөөр буюу 89,2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	245,492.12	280,546.30	35,054.18
Авлага	-	17,885.40	17,885.40
Урьдчилгаа			-
Бараа материал	79,630.40	111,886.60	32,256.20
Үндсэн хөрөнгө	333,663.51	327,894.00	-5,769.51
Нийт хөрөнгө	658,786.03	738,212.30	79,426.27
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	658,786.03	738,212.30	79,426.27
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	658,786.03	738,212.30	79,426.27

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн данс 35,054.1 мянган төгрөгийн өөрчлөлттэй байгаа нь хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх болсноор жилийн эцэст зарцуулагдаагүйтэй холбоотой мөнгөн хөрөнгийн данс 280,546.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын дансны үлдэгдэл 17,885.4 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авлага үүссэн байна.

Бараа материал 32,256.2 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалттай материал нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,769.51 мянган төгрөгөөр буурсан 4 хөрөнгө акталж устгасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 970,250.4 мянган төгрөг, нийт зарлагыг 970,250.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 970,250.4 зардлыг мянган төгрөг, 970,250.4 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2023 оны төсвийн төслийг бодитой тооцсон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 89,029.4 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр

971,250.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 45,961.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 971,250.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсвөөс 45,691.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 936,196.2 мянган төгрөг буюу 99,2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 35,000.0 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80302- Нэг иргэнд ногдох норматив	676,045.40	625,935.70	50,109.70	92,5%
2	81603- Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	205,175.50	299,319.50	(94,144.00)	145%
3	83601- нэмэлт	1,000.00	1,000.00	-	100%
4	83603- Дээд шатны төсвөөс хувиаралсан	129,650.90	129,650.90	-	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Байгууллагын тогтмол зардлын дансанд 45,961.1 мянган төгрөгийн санхүүжилт орж ирснээс 36,603.8 мянган төгрөгийг зарцуулж 9,357.3 мянган төгрөгийг Орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа бичиг хэргийн материал 4,193.0 мянган төгрөг, тээвэр шатахуун 36,527.6 мянган төгрөг, бага үнэтэй хурдан элэгдэх зөрдөл 9,669.5, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл 53,371.4 мянган төгрөг, хоол хүн 13,102.2 мянган төгрөг, урсгал засвар 66,928.6 мянган төгрөг зарцуулж нийт 220,400.5 мянган төгрөг төлөвлөснөөс 140,197.2 мянган төгрөгийг зарцуулж нийт 80,203.3 мянган төгрөгийг төсвийн хэмнэлт гарган ажилсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Эрдэнэсант сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ийн аудитор Б.Дашням, Шинжээч Д.Энх-Амгалан, Ө.Бат-Оюун нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүрсэн.

Эрдэнэсант сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 658,786.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 9,881.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,411.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь багаж хэрэгсэл, урсгал засвар, бага үнэтэй түргэн элэгдэх материал, тээвэр шатахууны зардлыг нийт 80,203.3 мянган төгрөгөөр хэмнэж ажилсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. Тайлант хугацаанд шилэн дансанд нийт мэдээлэх 159 мэдээллээс 150 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцорсон 5 мэдээлэл, 4 мэдээлэл байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг мөрдөн ажиллаагүй байна.

2. Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12 байгууллагын 322,132.8 мянган төгрөгийн зарлагыг өссөн дүнгээр оруулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Мөнгөн хөрөнгийн түүврийн горим сорил хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны цахим баримтын бүрдэлд 61,275.0 мянган төгрөгийн цахим баримт илүү шивэгдсэн зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авч үзэх

4.4.2.2 Төв аймгийн эрүүл мэндийн газраас эмийн сангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон, Эрдэнэсант сумын эрүүл мэндийн төвийн улсын бүртгэлийн гэрчилгээ дүрэмд эрхлэх үйл ажиллагаагаар бүртгэгдээгүй байгаа нь зөвшөөрлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн нийтлэг шаардлагад 1.1-д “иргэний эрх зүйн бүрэн чадамжтай байх”, 1.2-т “хуульд заасан бол мэргэжил, мэргэшлийн шалгалтад тэнцсэн, зохих дүгнэлт гаргуулсан

байх”, 1.3-д “татвар төлөгчөөр бүртгүүлсэн байх”, 2-т “Зөвшөөрөл эзэмшигч дараах үүрэг хүлээнэ”, 2.1-д “хуульд заасан баримт бичгийг үнэн зөв бүрдүүлэх”, 2.2-т “тухайн үйл ажиллагааг эрхлэх хуулиар тогтоосон нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах”, 2.3-д “хуулиар хориглосон, эсхүл хязгаарласан тохиолдолд зөвшөөрөлд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхгүй байх”, 2.4-д “хуульд өөрөөр заагаагүй бол зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг байнга эрхлэн явуулах”, 2.5-д “зөвшөөрлийг эрх бүхий этгээдээс авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ тухай татварын албанд мэдэгдэж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлэх”, 2.6-д, 3 дугаар бүлгийн 3.2.2-т заасан хуульд заасан зарчмыг баримтлах, 2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд зөвшөөрөл олгох гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авч үзэх

4.4.2.3 Эрдэнэсант сумын эрүүл мэндийн төв нь тусгай зөвшөөрлөөр эм худалдан борлуулах эмийн сангийн үйлчилгээг давхар эрхлэн явуулдаг, эргэлтийн эмийн сан нэртэй эрхзүйн чадамжгүй, сан нь үйл ажиллагаа явуулахдаа байрны түрээсийн төлбөр төлдөггүй түрээсийн орлого төсөвт төвлөрүүлээгүй, төсвөөс байр ашиглалтын төлбөр, эмийн сангийн эм зүйчийн цалин хөлс, шимтгэл, гэрэл цахилгаан, дулаан, ус, хог, тээвэр, шатахууны төлбөрийг төлж байгаа нь Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 20 дугаар зүйлд захирлын эрх үүрэгт 20.5-д “Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон энэ хууль, гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна”, 21 дүгээр зүйлд “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр хандив тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно” гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авч үзэх

4.4.2.4 Улсын бүртгэлийн гэрчилгээнд дээр хөрөнгийн хэмжээ 51,449.8 мянган төгрөг, санхүү байдлын тайлан дээр төрийн өмч 311,267.8 мянган төгрөг, Засгийн газрын оролцоо 259,818 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь санхүүгийн тайланд тусгагдсан ажил гүйлгээ буюу үйл явдал, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мэдээллийг үнэн зөв баталгаажуулах, бүртгэлдээ өөрчлөлтийг оруулдаг байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн татварын тухай, Төсвийн тухай хууль, Улсын бүртгэлийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар анхан шатны и-баримтын бүрдэл, Засгийн газар оролцоо сангийн бүртгэл, цалинтай холбоотой бүртгэл, шилэн дансны мэдээлэл, бичиг хэрэг хөтлөлт, өглөгийн данстай холбоотой бүртгэл, эмийн эргэлтийн сантай холбоотой нийт 8 зөвлөмж хүргүүлснээс 2 зөвлөмж 100 хувь хэрэгжүүлэн ажилласан, 6 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	30,286.6	1	0	0
Нийт дүн	1	30,286.6	1	0	0

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 30,286.6 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснөөс хэрэгжээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эмийн эргэлтийн сан нь байрны түрээсийн төлбөр төлдөггүй, хувь хүн иргэдэд олгосон цахим баримтыг байгууллагын регистрээр шивдэг, ашиглалтын зардал төлөхгүй байгаа асуудлыг авч үзэх, нормативт зардлын гүйцэтгэлийг давтан хянах, худалдан авалт хийхдээ үнийн харьцуулалт хийдэг эсэх, албан бичгээр харилцдаг эсэхийг авч үзэх.